



КРЕДИТ
ББСБ

2019

Ард Кредит

ЖИЛИЙН ТАЙЛАН

Хариуцлагатай
санхүүгийн
харилцаа
ирээдүйн
баталгаа

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ДҮГНЭЛТ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхний энэ өдрийн амар амгаланг эрье!

Юуны өмнө бидэнд итгэл үзүүлэн хамт байсан та бүхэндээ талархал илэрхийлж хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн өрөөе. Улиран одсон 2019 он Ард Кредитын хувьд үйл ажиллагаагаа эхлүүлсэн цагасаа хойшуйгагүй зүтгүүлсэн ажлын үр дүнг гаргаж, ирээдүйд бүтээх их үйлсийнхээ суурийг эцэслэн тавьсан жил болж өнгөрлөө.

Монголчууд үйлчлүүлдэг банк санхүүгийн байгууллагынхаа эзэн нь байх боломжтой гэдэг итгэл үнэмшилд хөтлөгдөн ажилласан он жилүүдийн үр шим нь гарч Ард Кредит нь 2019 оны I улиралд хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгож, Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй олон нийтэд хувьцаагаа нээлттэй арилжаалдаг компани болж чадлаа. Манай хувьцааг 1,600 гаруй иргэд эзэмшдэг боллоо. Бид оны эхэнд Хөрөнгө Оруулагч Үндэстэн Чуулганаар Ард Апп-ынхаа гайхамшигийг танилцуулж, олон нийтэд хүртээлтэй санхүүгийн онлайн үйлчилгээг амжилттай нэвтрүүллээ. Өнөөдөр Ард Аппыг хагас сая орчим хүн татан авч, бид 2019 онд нийт 75 мянган зээлийн олголт хийллээ. Оны эхэнд Ард Кредит 800-хан зээлдэгчтэй байсантай харьцуулбал бидний ажлын цар хүрээ ямар хэмжээнд хүрч өөрчлөгдөж байгааг харж болно.

Компанийн үйл ажиллагаа тэлж, бүтээгдэхүүн үйлчилгээ шинэчлэгдэхийн хэрээр харилцагч нартаа хүрч үйлчлэх шаардлагатай болдог. Тиймээс бид Монгол Шуудантай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласнаас гадна Харилцагчийн үйлчилгээний төвийг нийт 20 гаруй ажилтантайгаар шинээр байгууллаа.

Олонний тэднээлттэй хувьцаат компани болж, хөрөнгийн зах зээл дээр хувьцаагаа арилжаалж эхэлсний хувьд холбогдох хууль, журмын дагуу өөрчлөн байгуулагдсан даруйдаа компанийн засаглалтай холбоотой дүрэм, журмыг шинэчлэн батлуулах, холбогдох байгууллагуудад хүргүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэлээ. Мөн Монголбанкны зүгээс тавьсан шаардлагын дагуу бид Цахим мөнгөний тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ гаргаж, тэдний зүгээс хариуг хүлээж байна.

Тайлант онд ТУЗ нийт 6-7 удаа хуралдаж, хувьцаа эзэмшигчдийн хурлаа 2 удаа хийллээ. 2019 оны төсөв төлөвлөгөөний гүйцэтгэлийг 100 хувь хангаж, оны эцсийн санхүүгийн тайлангаар 2.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд дээрх ашгийн 50 хувийг ногдол ашиг хэлбэрээр тараахыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэрлээд байна.

Энэхүү тайлан бичигдэж байх цаг үед дэлхий даяар Новел Коронавирус дэгдэж, ДЭМБ-аас цар тахлын хэмжээнд аваачиж зарлалаа. Ингэснээр Монгол улсын



хувьд 2020 он нийгэм, эдийн засгийн хувьд бужигнасан, тодорхойгүй зүйл ихтэй бизнесийн орчинд амаргүй жил болохоор байна. Хэдий байдал ийм байгаа ч бид хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч та бүхэндээ амласан амлалт, төлөвлөгөөндөө хүрэхийн тулд цаг үеийн шийдвэрийг түргэн шуурхай гарган, харилцагчдын үйлчилгээгээ таслалгүй, ажилласдынхаа аюулгүй байдлыг хангаж, компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах болно.

Ард Кредитэд анх 2013 онд хөрөнгө оруулахаас эхлээд Ард Санхүүгийн Нэгдэл дор өөрчлөн байгуулах, ребрэндинг хийх ажлыг хариуцаж, өдий хүртэл удирдаж ирсэн. Гүйцэтгэх Захирал Ч. Ганзориг 2019 оны 6 дугаар сардөөражилэрхлэхээрявахболсон билээ. ТУЗ-ийнхувьд онцгой горимоор ажиллаж, холбогдох шийдвэрүүдийг гаргаж, компанийн удирдлагыг тасалдалгүй хангах үүргийг ТУЗ-ийн даргад даалгасан юм. Ч.Ганзоригтой байгуулсан гэрээг дүгнэх, компанийн үйл ажиллагааг доголдуулахгүй, өдөр тутмын удирдлагаар хангах, олон нийт, хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах, дараачийн Гүйцэтгэх захирлыг хайж, олох ажлыг бид зохион байгуулж, оногдсон үүргээ нэр төртэй биелүүлсэн гэж дүгнэж байна. 2019 оны сүүлчийн хагаст Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр ажилласан Г.Сүхбаатарт та бүхний нэрийн өмнөөс талархал илэрхийлье. Бид оны сүүлээр Монгол Шуудангийн дэд захирлаар ажиллаж

байсан Г.Тэлмэнг Ард Кредитын Гүйцэтгэх захирлаар томилох тухай шийдвэрийг гаргаж, 2020 оны 2 дугаар сараас тэрээр байгууллагын жолоодлогыг гартаа авлаа. Бидний ажил үйлс, алсын хараа, ур чадварт итгэж, цаг ямагт бидэнтэй хамт байсан хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажиллагч та бүхэндээ дахин талархал илэрхийлж, мэхийн ёсольё.

Та бүгдээ амжилт бүтээлийн дээд, эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Бид ямагт сэтгэлийн Хүчтэй. Хамтдаа байхдаа бүр ялагдашгүй!

ТУЗ-ийнхөө нийт гишүүдийн өмнөөс та бүгдтэй мэндчилсэн,

**Хутагт овгийн Ч. Ганхуяг,
ТУЗ-ийн Дарга,
Ард Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх Захирал**



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт харилцагч, бизнесийн түвш, хувьцаа эзэмшигчид болон хамтран ажиллагсад та бүхнийхээ амар амгаланг эрэн мэндчилье.

2019 он Ард Кредит ББСБ ХК-ийн хувьд үүсгэн байгуулагдсан цагаас хойш өмнөө тавьсан зорилтуудынхаа гүйцэтгэлээр салбartaа манлайлсан, компанийн алс ирээдүйн хөгжил дэвшлийн чиг хандлага, өнгө төрхийг тодорхойлсон онцгой нэгэн он цаг байлаа. Бид 2019 оны I улиралд Ард Апп-ын эхний хувилбарыг зах зээлд амжилттай нэвтрүүлж байсан бол өдгөө 3 дахь хувилбарыг олон нийтэд танилцуулж, харилцагчид маань Ард Апп-ыг ашиглан санхүүгийн бүх төрлийн үйлчилгээ авах боломжтой боллоо. Тайлант оны эцэст харилцагчийн тоо 200.5 мянга, зээлдэгчдийн тоо 25.4 мянгад хурсэн нь бидний үйл ажиллагаа өргөжин тэлж байгаагийн тод илрэл юм.

2013 оноос 2019 оны 7 сарын 30-ны өдрийг хүртэл компанийн хөгжлийг түүчээлж, тасралтгүй, амжилттай удирдаж, манлайлж ирсэн Гүйцэтгэх захирал Ч.Ганзориг болон 2019 оны 7 сарын 31-ний өдрөөс Гүйцэтгэх захирлын үргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажилласан Г.Сүхбаатар нарт гүнээ талархал илэрхийлье.

Компанийн үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр Ард Апп хэрэглэгчдийн тоо эрчимтэй өссөөр байна. Бид үйлчилгээгээ илүү хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх эрхэм зорилгынхoo хүрээнд Монгол орны өнцөг, булан бүрт салбар нэгжтэй Монгол Шуудан ХК-тай Стратегийн түншлэлийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Мөн харилцагчдаа халамжлах, тэдгээрт хэрэгцээтэй мэдээлэл, зөвлөгөөг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэх зорилгоор Харилцагчийн үйлчилгээний төвийг Колл Про ХХК-тай хамтран амжилттай байгууллаа.

Компанийн үйл ажиллагаа гадаадын дэмжигч байгууллагуудад өндөөр үнэлэгдсэний тод жишээ нь Япон улсын Kraud Кредит хөрөнгө оруулалтын сантай хамтран ажиллах хэлэлцээр амжилттай хийж, нийт 9 удаагийн санхүүжилтээр 2.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлснээр илэрхийлэгдэж буй. Мөн Латви улсын Mintos, БНЧУ-ын Bondster зэрэг хөрөнгө оруулалтын сангидтай хамтран ажиллах санал хүргүүлэн, таатай хариу хүлээн авсан юм.

Мөн Төлбөр тооцооны үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор Монголбанкны Төлбөр тооцооны хэлтэст Цахим мөнгөний тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргаад байна.

Компанийн хөгжлийг хурдасгах, программ хангамжийн дэд бүтцийг харилцагчдын хүсэл хэрэгцээнд нийцүүлэн шийдвэрлэх зорилтынхoo хүрээнд Грэйпсити Монгол ХХК болон Мост Финтек ХХК-тай стратегийн түвшинд хамтран ажиллаж эхэлснийг мэдэгдэхэд таатай байна.


Миний бие 2020 оны 2 сараас эхлэн Ард Кредит ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байгаа бөгөөд үүрэгт ажлаа хүлээн авсан үеэс нээлттэй хувьцаат компанийн хувьд компанийн хөгжлийг 3-5 жилээр стратегийн түвшинд тодорхойлох, бизнес процессуудыг илүү хурдан, харилцагчдад хялбар, алдаа дутагдал багатай байхад чиглэсэн ажлуудад төвлөрч байна.

Бидний хамтдаа хийж бүтээх үйл хэрэг нийт хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг дээдэлсэн, хөрөнгө оруулагчдын хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлсэн, харилцагчдынхаа сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн байхад чиглэх болно.

Мэндчилгээ бичигдэж байх энэ цаг үед дэлхий нийтэд Коронавирус /COVID-19/-ын халдвар дэгдэн эдийн засаг, бизнесийн орчин ихэд хүндэрч байгаа хэдий ч бизнес тасралтгүй үргэлжилж байх зарчмыг баримтлан цаг үеийн шийдвэрийг түргэн шуурхай гарган, компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгааг та бухэнд мэдэгдэхэд таатай байна.

Үргэлж бидэнтэй хамт байсан, хамт байгаа хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, хамтран ажиллагсад та бүхэндээ эрүүл энх, амжилт бүтээл, сайн сайхан бүхнийг хүсэн ерөө.

**Хүндэтгэсэн,
Гүйцэтгэх захирал Г. Тэлмэн**



Алсын хараа

Ард Кредит нь санхүүгийн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэн зах зээлд манлайлж ажиллана

Эрхэм зорилго

Бид Монгол улсад санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, санхүүгийн боловсролыг дэлгэрүүлэх зорилго бүхий нийгмийн хариуцлагын тэргүүлэгч байгууллага болно.

Үнэт зүйл

- Сэтгэл хангалийн хэрэглэгчид
- Хэрэглэгч төвтэй шинэлэг үйлчилгээнүүд
- Нийгмийн хариуцлага
- Хөрөнгө оруулалтын тогтмол, ашигтай өгөөжийн түвшин

Түүхэн замнал

Ард Кредит нь 2011 онд Интергрупп Интернейшнл ХХК-ийн хөрөнгө оруулалтаар байгуулагдсан ба 2013 онд Ард Санхүүгийн Нэгдэл хөрөнгө оруулалт хийснээр шинэ удирдлага, стратегиар ажиллаж эхэлсэн.

Ард Кредит нь дэвшилтэт технологийн тусламжтайгаар харилцагчиддаа шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэн, үйлчилгээгээ Монгол улсын өнцөг булан бүрт хүргэх зорилго тавин ажиллаж байна.

Уг зорилтын хүрээнд бид 2019 оны I улиралд Ард Апп All-in-One ухаалаг гар утасны аппликашний 2 дахь хувилбарыг, 2019 оны IV улиралд 3 дахь хувилбарыг амжилттай нэвтрүүлснээр нийт 200.5 мянган харилцагчидтай болоод байна. Мөн 2019 оны I улиралд компанийн 25% болох 70,000,000 ширхэг хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгосноор анхдагч зах зээлийн захиалга 299 хувь давж биелэн Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон билээ.

2013

- Ард Санхүүгийн Нэгдэл ХК хөрөнгө оруулалт хийснээр шинэ удирдлага, стратегитайгаар ажиллаж эхлэв.

2015

- Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдэл нь компанийн 58 хувийг эзэмших болов.
- Бичил Санхүүгийн Хөгжлийн Сангаас хөнгөлөлттэй санхүүжилт авч, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зээл олгож эхлэв.
- Хөдөөгийн бичил санхүүгийн байгууллагуудад бөөний зээл олгож эхлэв.

2011

- Интергрупп Интернейшнл ХХК-ийн хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдваа.

2014

- СЗХ-ны зөвшөөрлөөр анхны хаалттай өрийн бичгээ амжилттай гаргаж нийт 550 сая төгрөгийн санхүүжилт босгов.
- Хувьцаа эзэмшигчиддээ анхны ногдол ашиг хуваарилав.
- Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагааны чиглэлээ өргөжүүлэв.
- Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан-тай хамтран ажиллаж, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой айл өрхүүдэд хөнгөлөлттэй зээл олгож эхлэв.

2018

- Олон улсын мөнгөн гүйвуулгын EuroGi-ro систем болон Монгол Шуудан ХК-тай хамтран Олон улсын мөнгөн гүйвуулгын үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг амжилттай эхлүүлэв.
- Монгол Шуудан ХК-ийн салбаруудаар дамжуулан харилцагчиддаа санхүүгийн үйлчилгээгээ хүргэж эхлэв.
- Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос IPO хийх зөвшөөрөл аван үнэт цаасаа бүртгүүлэв.
- Санхүүгийн Зохицуулах Хорооноос цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээний тусгай зөвшөөрөл авав.
- Компанийн ТУЗ нь 2017 онд цэвэрэашгийн 50 хувийг хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хэлбэрээр хуваарилах шийдвэр гаргав.
- 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 3 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлэв.
- Япон улсын Крауд Кредит хөрөнгө оруулалтын сангаас 13 орчим тэрбум

төгрөгийн санхүүжилт авах тухай хэлэлцээр хийгдэж, 2019 оны I улиралд эхний санхүүжилтийг хүлээн авахаар боллоо.

- Овердрафтын зээлийн бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлэв.
- Хүүгүй, барьцаагүй зээлийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.
- ББСБ-уудаас салбартаа анхлан хувьцаа барьцаалсан зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.
- ГрэйпСити Монгол ХХК-ийн банкны үндсэн систем болох Поларис системийг үйл ажиллагаандaa амжилттай нэвтрүүлэв.
- Санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх Ард Апп-ын эхний хувилбарыг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.
- Ард Санхүүгийн Нэгдлийн санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх салбар Сэнтрал Таурт нээгдэж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос салбарын тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаагаа явуулж эхлэв.

2017


- ББСБ-уудаас салбартаа анхлан Кредит картын бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.
- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудаас салбартаа хамгийн бага зээлийн хүүтэй байгууллага болон ажиллаж эхэлсэн.
- ГрэйпСити Монгол ХХК-тай стратегийн түвшинд хамтран ажиллахаар болж, Поларис үндсэн банкны систем болон Мост Мони үйлчилгээг нэвтрүүлэх гэрээ байгууллаа.
- 2017 оны 6 сарын 22-нд Санхүүгийн Зохицуулах Хорооноос Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллав.

Бүтэц, зохион байгуулалт

Ард Кредит нь олон улсын жишигт нийцэхүйц компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэн Монгол улсын Банк бус санхүүгийн салбарт жишиг байгууллага болон ажиллаж байна. Компанийн засаглалын үр дүнг нэмэгдүүлэх суурь

нөхцөл нь ТУЗ-ийн дэргэдэх хороодын идэвхтэй үйл ажиллагаабайдаг бөгөөд тус Хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал, дүгнэлт гарган ажиллаж байна.





- Уламжлалт зээл гаргахад 3 хоногийн хугацаа шаардагддаг байсан бол Ард Арг-аар 3-5 минутад зээл олгодог болов.
- Renault Kaptur загварын цоо шинэ 2 авто машиныг сугалааны тохиролд бэлэглэв.

2019 оны онцлох үйл явдал



2019.01 2019 оны 1 сарын 18-нд Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2019 Чуулга уулзалтын үеэр Санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх Ард Аппын 2 дахь хувилбарыг олон нийтэд танилцуулав.

2019.01 Монгол Шуудан ХК-ийн салбаруудаар дамжуулан харилцагчиддаа санхүүгийн үйлчилгээгээ хүргэж эхлэв.

2019.01 2019 оны 1 улиралд хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгосноор олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн захиалга төлөвлөснөөс 299 хувь даван биелэсэн. Ингэснээр олон нийтээс 5.3 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлж, 1,500 гаруй шинэ хувьцаа эзэмшигчтэй нээлттэй хувьцаат компани болов.

2019.01 Япон улсын Крауд Кредит хөрөнгө оруулалтын сантай 5 сая долларын санхүүжилт авах хэлэлцээр хийсний дагуу, 9 удаагийн санхүүжилтээр 2.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэв.

2019.04 Хувьцаат компани болон хэлбэрээ өөрчилсний дараах анхны хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2019 оны 4 сарын 27-ны өдөр 81%-ийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулав.

2019.04 ТУЗ-ийн ээлжит хурлыг 4 удаа, ТУЗ-ийн дэргэдэх хороодын ээлжит хурлыг 4 удаа амжилттай зохион байгуулсан.

2019.05 Дэлхийн 36 улсын 100 гаруй байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн, Варшав хотод



байршилтай ""Бичил Санхүүгийн Төв"-өөс зохион байгуулсан 2019 оны хурлын Алтан спонсороор ажиллаж, баг, хамт олноороо амжилттай оролцсон. Гадны олон зочид хуран чуулсан уг хурлаар Ард Апп-ыг олон улсын хөрөнгө оруулагчдад албан ёсоор танилцуулав.

2019.07 Гүйцэтгэх захирал Ч.Ганзориг үүрэгт ажлаа хүлээлгэн өгч, Г.Сүхбаатар Гүйцэтгэх захирлын үргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж эхлэв.

2019.09 Монголбанкинд цахим мөнгөний тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргав.

2019.09 2019 оны 9 сард Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулахаар

Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэрлэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас Компанийн дүрмийг шинэчилсэн найруулгаар батлав.

2019.12 Санхүүгийн Зохицуулах Хороонд хаалттай бонд гаргах хүсэлт гаргаж, 2 тэрбум төгрөгийн зөвшөөрөл авав.

2019.12 Санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх Ард Апп-ыг дизайн, ашиглалтын хувьд шинэлэг, илүү хялбар, олон боломжийг багтаасан байдлаар шинэчилж, 3 дахь хувилбарыг 2019 оны 12 сарын 1-нд Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2020 Чуулга уулзалтын үеэр олон нийтэд танилцуулав.

ҮНЭТ ЦААС

Үнэт цаасны төрөл

Тикер

Анхдагч захиалга

Олон нийтэд санал болгох хувьцааны тоо

Нэрлэсэн үнэ

Олон нийтэд санал болгох хувьцааны хувь

Санал болгох хувьцааны үнэ

Нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ

Олон нийтэд санал болгосны дараах хувьцааны тоо

Энгийн хувьцаа

ADB

2019/02/18 - 2019/03/01

70,000,000 ширхэг

10 төгрөг

25 хувь

70 - 85 төгрөг

4,900,000,000 төгрөг

280,000,000

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Гүйцэтгэх захирылын 2018 оны 11 сарын 30-ны өдрийн А/133 тоот тушаалаар Ард Кредит ББСБ ХК (Ард Кредит)-ийн үнэт цаасыг бүртгэж, анхдагч зах зээлийн хувьцааны захиалга явагдаж, компанийн 25 хувь буюу 70,000,000 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд санал болгосон.

Стратегийн хөрөнгө оруулагчдаас 2.5 тэрбум төгрөг босгосон бол олон нийтэд санал болгосон хэсэгт нийт 1,763 хувь хүн, аж ахуй нэгжээс 7.3 тэрбум төгрөгийн захиалга ирж, захиалга олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээнээс даруй 299 хувь давж биелэсэн.

ADB тикер дор бүртгэгдэх хувьцааны олон нийтэд санал болгосон 35 сая ширхэг хувьцааг Монголын Хөрөнгийн Биржийн "Анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын захиалгын бүртгэлийн аргыг ашиглан 70-85 төгрөгийн хооронд санал болгосон юм.

Захиалгын дийлэнх нь 85 төгрөг байсан хэдий ч үнэт цаас гаргагч болон андеррайтер компаниудын зүгээс Монголын Хөрөнгийн Биржийн журам, хөрөнгө оруулагчдад өгөх өгөөж, хүртээмжийг харгалзан үзэж, нэгж хувьцааны нийлүүлэх үнийг нийт ирүүлсэн захиалгын тоо хэмжээгээр жигнэсэн дундаж ханш буюу 81 төгрөгөөр тогтсон.

Ард Кредитын нэгж хувьцааны үнийг 81 төгрөгөөр тогтоосноор олон нийтээс 2.8 тэрбум төгрөг, стратегийн хөрөнгө оруулагчдаас 2.5 тэрбум төгрөг, нийт 5.3 тэрбум төгрөг татан төвлөрүүлж, өөрийн хөрөнгөе нэмэгдүүлэх боломжтой болсон.


Тэргүүн андеррайтераар Ард Капитал УЦК
Туслах андеррайтераар Ард Секюритиз УЦК
Хуулийн зөвлөхөөр И Эл Си ХХК
Хөндлөнгийн үнэлгээчнээр БДО Аудит ХХК
Хараат бус Аудитороор Далайван Аудит ХХК тус тус ажиллав.

Ард Кредитын хувьцааны арилжаа

Ард Кредит ББСБ нь ХК болж 3 сарын 12-ны өдөр хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлснээр нийт 34.7 сая ширхэг хувьцаа 2.74 тэрбум төгрөгний дүнтэй арилжаалагдлаа.

52 долоо хоног	₮65 - ₮87.83
Зах зээлийн үнэлгээ	₮22.06 тэрбум
Нийт хоёрдогч арилжааны дүн	₮2.74 тэрбум
Хаалтын үнэ	₮81.49
Дансны үнэ	₮38.8
P/E - Үнэ/Ашиг	9.29
P/B - Үнэ/Дансны үнэ	2.02

MSE:ADB



Хувьцаа ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Ард Кредит ББСБ ХК-ийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. 2019 онд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 1 удаа, ээлжит бус хурал 1 удаа тус тус хуралдсан байна. Компани хязгаарлагдмал хариуцлагатай компаниас Хувьцаат компани болон хэлбэрээ өөрчилсний дараах анхны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 сарын 27-ны өдөр зохион байгуулагдаж, компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталгаажуулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох шийдвэрүүдийг гаргасан билээ. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон менежментийн баг дээрх шийдвэрийн хэрэгжилтийг ханггуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн юм.

Мөн Төлөөлөн удирдах зөвлөлөөс жижиг хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх, ашгийг хамгаалах үүднээс компанийн дурмийг шинэчилсэн найруулгаар батлуулахаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулж, 2019 оны 11 сарын 14-ний өдөр эчнээ саналын хуудсыг тоолж, Компанийн дурмийг шинэчилсэн найруулгаар батлах шийдвэрийг албан ёсоор гаргасан байна.

Огноо	Ирц	Шийдвэрлэсэн асуудлууд
2019.4.27	81%	<ol style="list-style-type: none">2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
2019.11.14	87.32%	1. Компанийн дурмийг шинэчилсэн найруулгаар батлах;

Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс Ард Кредит ББСБ компанийг нээлттэй хувьцаат компани болон хэлбэрээ өөрчлөх, хувьцаагаа хөрөнгийн зах зээлд гарган олон нийтэд нээлттэй худалдах зөвшөөрлийг олгосны дараа 2019 оны 2 сарын 18-ны өдрөөс 3 сарын 1-ний өдрийн хооронд хувьцааны анхдагч арилжааны захиалгыг хөрөнгө оруулагчдаас хүлээн авч, 2019 оны 3 сарын 6-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлсэн байна.

Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны дараа Ард Кредит ББСБ ХК нь 1,432 хувьцаа эзэмшигчтэй байсан бөгөөд оны эцсийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн тоо 1,588 болон нэмэгдсэн байна.

Хувьцаа ЭЗЭМШИГЧДИЙН БУТЭЦ

	Хувьцаа эзэмшигч	2019	Хувь
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК	170,464,714	60.88%
2	С.Гэрэлтуяа	26,768,372	9.56%
3	В.Баяржаргал	14,593,398	5.2%
4	Ард Лайф ХХК	8,630,005	3.08%
5	И.Баттуяа	5,823,084	2.07%
6	Ард Бит ХХК	4,938,716	1.76%
7	Моннис Интернэйшнл	3,571,430	1.27%
8	Н.Даваасүрэн	3,571,428	1.27%
9	А.Сүхдорж	3,571,428	1.27%
10	Э.Жононбаяр	3,571,428	1.27%
11	Тээвэр Хөгжлийн банк ХХК	3,492,857	1.24%
12	И Ай Ти ХХК	2,887,722	1.03%
13	Х.Гантөмөр	2,352,425	0.8%
14	Ард Даатгал ХК	1,781,607	0.6%
15	Х.Нямбадраа	1,330,000	0.47%
Топ хувьцаа эзэмшигчид		257,348,614	91.8%
Бусад хувьцаа эзэмшигчид		22,651,386	8.2%
Нийт гаргасан хувьцаа		280,000,000	100.0%
Хувьцаа эзэмшигчидийн тоо		1,481	

Төлөөлөн Удирдах Зөвлөл

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 3 сарын 6-ны өдрийн 1/820 тоот тогтоолоор Ард Кредит ББСБ ХК-ийг хувьцаат компани болгон хэлбэрээ өөрчлөх зөвшөөрөл олгосонтой холбогдуулан Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийг 9 гишүүнтэй болгон өргөжүүлж шийдвэрлэсэн бөгөөд 2019 оны 4 сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн ердийн гишүүнээр Ч.Ганхуяг, Ч.Ганзориг, В.Баяржаргал, С.Гэрэлтуяа, М.Тулгат нарыг, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр В.Ганзориг, И.Баттуяа, Б.Чулуунбаатар, Б.Ганбат нарыг тус тус томилсон. Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д заасны дагуу “.....тэдгээрийн гуравны нэгээс доoshгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэж заасны дагуу өнөөдрийн байдлаар 5 ердийн, 4 хараат бус гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

ТУЗ-ийн даргаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирал Чулууны Ганхуяг ажиллаж байна.

2019 оны 4 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөл шинэ бүрэлдэхүүнээр анхны ээлжит хурлыг 2019 оны 7 сарын 5-ны өдөр зохион байгуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Чулууны Ганхуягийг томилж, Төлөөлөн удирдах

зөвлөлийн дэргэдэх Санхүү, зээл, эрсдэлийн хороо, Засаглал, нэр дэвшиүүлэх, цалин урамшууллын хороо, Дотоод аудитын хороог шинэ бүтэц бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан.

Үүнд:

Дотоод аудитын хороо

- 1.Б.Ганбат /Дарга/- ТУЗ-ийн хараат бус гишүүн
- 2.В.Ганзориг – ТУЗ-ийн хараат бус гишүүн
- 3.И.Баттуяа- ТУЗ-ийн хараат бус гишүүн
- 4.М.Тулгат- ТУЗ-ийн ердийн гишүүн
- 5.М.Мөнх-Эрдэнэ-Хорооны нарийн бичгийн дарга

Засаглал, нэр дэвшиүүлэх, цалин урамшууллын хороо

- 1.В.Баяржаргал /дарга/- ТУЗ-ийн ердийн гишүүн
- 2.Б.Ганбат- ТУЗ-ийн хараат бус гишүүн
- 3.Б.Чулуунбаатар – ТУЗ-ийн хараат бус гишүүн
- 4.М.Мөнхсүрэн-Хорооны нарийн бичгийн дарга

Санхүү, зээл, эрсдэлийн хороо

- 1.Ч.Ганзориг /дарга/- ТУЗ-ийн ердийн гишүүн
- 2.С.Гэрэлтуяа- ТУЗ-ийн ердийн гишүүн
- 3.В.Ганзориг – ТУЗ-ийн хараат бус гишүүн
- 4.В.Баяржаргал – ТУЗ-ийн ердийн гишүүн
- 5.Б.Ганбат – ТУЗ-ийн хараат бус гишүүн
- 6.Б.Оюутцэцэн- Хорооны нарийн бичгийн дарга

ТУЗ-ийн дэргэдэх хороодыг зохион байгуулахдаа Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т заасны дагуу Дотоод аудитын хороо, Засаглал, нэр дэвшиүүлэх, цалин урамшууллын хороодын гишүүдийн 2/3-оос доoshгүй нь хараат бус гишүүн байх, мөн тус хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4-т заасны дагуу Дотоод аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх хуулийн шаардлагыг хангулсан.

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь тогтмол хуралдаж, жилийн турш ТУЗ-ийн хурлын өмнө хурлаар шийдвэрлэх асуудал бүрээр урьдчилсан хэлэлцүүлэг явуулж, хорооны саналыг ТУЗ-д танилцуулж, шийдвэр гаргуулж ажиллалаа. ТУЗ-ийн нийт гишүүд компанийн засаглалын сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэн зөвшөөрөл авсан болно.



Чулууны Ганхуяг

ТУЗ-ийн дарга



Чулууны Ганзориг

ТУЗ-ийн ердийн гишүүн

Санхүү, зээл, эрсдэлийн хорооны дарга



Сэдбазарын Гэрэлтуяа

ТУЗ-ийн ердийн гишүүн



Ванданцэрэнгийн Баяржаргал

ТУЗ-ийн ердийн гишүүн

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын
хорооны дарга



Майнбаярын Тулгат

ТУЗ-ийн ердийн гишүүн



Ванчигийн Ганзориг

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Барамсайн Ганбат

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Дотоод аудитын хорооны дарга



Базын Чулуунбаатар

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Ишдоржийн Баттуяа


ТУЗ-ийн хараат бус гишүүн

Гүйцэтгэх удирдлагын өөрчлөлт

Ард Кредит ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирлаар 2013 оноос хойш ажилласан Чулууны Ганзориг өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт өгснөөр Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 7 сарын 31-ний өдрийн хурлаар Гүйцэтгэх захирал Чулууны Ганзоригийг

үүрэгт ажлаас чөлөөлж, Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Гүррагчаагийн Сүхбаатарыг томилсон билээ. Улмаар 2019 оны 12 сарын 17-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлаар Гүйцэтгэх захирлын залгамж халааг төлөвлөж, 2020 оны 1 сарын 27-ны өдрөөс Гүйцэтгэх захирлаар Гэрэлтийн Тэлмэнг томилохоор шийдвэрлэсэн болно.

Ард Апп



Зээл олголт

76.3 мянга

Зээл төлөлт

151.3 мянга

Зээлийн хүсэлт

1.2 сая

Зээлийн багц

10.5 тэрбум

Дундаж зээлийн хэмжээ

426 мянга

2 удаагийн шинэчилсэн хувилбар

400 мянган Апп таталт

200.5 мянган Харилцагч

41 мянган Гэрээт харилцагч

25.4 мянган Зээлдэгч

АРД АПП
VERSION 3.0

ЗЭЭЛИЙН ҮЙЛ ажиллагаа



Нийт зээл



Онлайн зээл



Бизнесийн зээл



Хэрэглээний зээл

Ард Кредит нь зээл олгох, цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулга, итгэлцэл татах зэрэг 7 төрлийн санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг. Компани нь үйл ажиллагаагаа Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд явуулдаг бөгөөд 2019 онд нийт 76,723 иргэн, аж ахуй нэгжид 42.8 тэрбум төгрөгийн зээл олгох, нийт зээлдэгчийн тоо 76.2 мянгад хүрэв. Тайлант хугацаанд нийт зээлийн 82 хувийг онлайн зээл, 10 хувийг бизнесийн зээл, 8 хувийг хэрэглээний зээл эзэлжээ.

САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

Чанаргүй зээлийн хувь

2017: 5.5%
2018: 4.2%
2019: 6.5%

Төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа:

2017: 22.3%
2018: 18.1%
2019: 15.1%


Үндсэн хөрөнгийн зохицой харьцаа:

2017: 2.3%
2018: 2.1%
2019: 2.9%


Өр хөрөнгийн харьцаа:

2017: 42.1%
2018: 63.3%
2019: 53.6%


Нийт хөрөнгө /сая.төгрөг




Цэвэр зээл /сая.төгрөг




Санхүүжилтийн өглөг /сая.төгрөг




Өөрийн хөрөнгө /сая.төгрөг



Үйл ажиллагааны орлого /сая.төгрөг



Цэвэр ашиг /сая.төгрөг



Нийгмийн хариуцлага



Даян дэлхийн Нэр төрөө эрхэмлэх өдөр

"Даян дэлхийн нэр төрөө эрхэмлэх өдөр"-ийг тэмдэглэн 29 дүгээр тусгай дунд сургуулийн сурагчдад "Нэр төр гэж юу вэ?" сэдэвт лекц, хэлэлцүүлэг зохион байгуулан, сурагч хүүхдүүдэд гарын бэлэг гардуулав. Уг арга хэмжээнд Ард Кредитын 2019 оны шилдэг шинэ ажилтан Θ.Мөнхтөр сурагчдад "Нэр төр"-ийн талаарх өөрийн үзэл бодол, амьдралын туршлага, түүхээс сурагч хүүхдүүдэд хуваалцсан юм.



Үргэлж бэлэн бай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2019 оны 6 сарын 15-нд анх удаа зохион байгуулагдсан Кросс Фитнесийн "ҮРГЭЛЖ БЭЛЭН БАЙ"uriатай "Murph Challenge 2019" тэмцээнийг хамтран зохион байгуулж, ивээн тэтгэв.




Бусдын төлөө цусаа өгч, амьдрал бэлэглэе

Ард Санхүүгийн Нэгдэл нь сайн дурын цусны донорын эгнээг өргөжүүлэх, хүмүүнлэгийн үйлсийг олон нийтэд сурталчлан уриалах зорилгоор Цус сэлбэлт судалалын үндэсний төвтэй хамтарсан үйл ажиллагааг дэмжих ажиллалаа.

Хүний нөөц

Ард Кредитын үйл ажиллагааны бүтэц, хүний нөөц нь компанийн үндсэн чиглэл болох зээлийн үйл ажиллагаанд төвлөрдөг бөгөөд бусад функциуд болох мэдээлэл технологи, дотоод аудит зэргийг толгой компаниас менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээгээр авдаг. Ингэснээр үндсэн чиглэл, үйл ажиллагаанд илүү төвлөрч, бага зардлаар үйл ажиллагаага явуулах бололцоотой болдог. Мөн ажилтан бүрийг 20 сая төгрөгийн хамгаалалт бүхий эрүүл мэндийн даатгалд хамруулсан.



Харилцагчийн бүртгэлийн алба

Харилцагчийн бүртгэлийн алба нь Ард Кредит ББСБ болон Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн охин компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээг авч байгаа нийт харилцагчдын бүртгэлийг хянах, Монгол Шуудан ХК-ийн 29 салбараар Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ, Цахим зээлийн эрх нээх гэрээ түүний хавсралтыг байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, гэрээтэй холбоотой бүртгэл, хяналтыг зохицуулахад чиглэн ажилладаг.

2019 онд нийт 256,330 харилцагч бүртгэгдсэнээс 41,567 харилцагч нь Fast Cash зээлийн гэрээг байгуулсан. Үүнээс 36,862 харилцагчийн гэрээг Монгол Шуудан ХК-ийн салбараар, 4,705 харилцагчийн гэрээг өөрийн салбараар дамжуулан байгуулсан байна



300,742 цагийн хооронд

Нийт дуудлага	300,742
Амжилттай хариулсан	225,037
Амжилттай хариулсан дуудлагын хувь	74.8%
1 харилцагчтай холбогдох дундаж хугацаа	01:26 секунд

Харилцагчийн үйлчилгээний төв

2020 онд харилцагчдаа халамжлах, хэрэгцээтэй мэдээлэл, зөвлөгөөг түргэн шуурхай хүргэх зорилгоор Харилцагчийн үйлчилгээний төвийг байгууллаа.

Уг төв нь Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний харьянд байдаг охин компаниудын зах зээлд үзүүлж буй

бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх бүх төрлийн мэдээ мэдээллийг түргэн шуурхай өгч ажилладаг билээ. Харилцагчийн үйлчилгээний төвийн систем, программ хангамжийг КоллПро ХХК-ийн үйлчилгээ, дэд бүтцээр шийдсэн бөгөөд харилцагч бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтээ 77003322 лавлах утас, и-мэйл болон фейсбуук чатын үйлчилгээгээр дамжуулан хүргэх боломжтой болсон



20 ажилтан



Өдөр бүр **08:00 - 22:00**
цагийн хооронд



1:26

1 харилцагчтай холбогдох
дундаж хугацаа



Эдийн засгийн орчин

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусlamжийн хэмжээ 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 11.9 их наяд төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусlamж нь 10.8 их наяд төгрөг болж, нийт орлогын 90.5 хувийг эзэлж байна. Харин нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 11.4 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 627.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 81.7 хувийг татварын орлого, 8.8 хувийг татварын бус орлого, 8.7 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 0.8 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Татварын нийт орлого 2019 онд 9.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 18.8 хувиар буюу 1.5 их наяд төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 22.1 хувь буюу 460.8 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 21.9 хувь буюу 355.0 тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 13.1 хувь буюу 288.0 тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 28.8 хувь буюу 205.2 тэрбум төгрөг, онцгой албан татвар 14.4 хувь буюу 109.0 тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 15.8 хувь буюу 107.7 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Татварын орлогод орлогын албан татвар 26.1 хувь, нэмэгдсэн

өртгийн албан татвар 25.5 хувь, нийгмийн даатгалын орлого 20.3 хувь бусад татвар 11.2 хувь, онцгой албан татвар 8.9 хувь, гадаад үйл ажиллагааны орлого 8.1 хувийг эзэлж байна. Нийт татварын орлогод орлогын албан татварын эзлэх хувь 0.7 пункт, бусад татвар, хураамжийн орлого 0.6 пункт, нийгмийн даатгалын сангийн орлого 0.5 пунктээр өсөж, нэмэгдсэн өртгийн албан татвар 1.3 пункт, онцгой албан татвар 0.3 пункт, гадаад үйл ажиллагааны орлого 0.2 пунктээр буурсан байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 11.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 23.9 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өссөн байна. Зарлагын өсөлтөд урсгал зардал 11.7 хувь буюу 859.7 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 51 хувь буюу 136.2 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 75.3 хувь буюу 1.2 их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дунд урсгал зардал 71.8 хувь, хөрөнгийн зардал 24.7 хувь, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 3.5 хувийг эзэлж байна. Урсгал зардалд бараа үйлчилгээний зардал 48.6 хувь, урсгал шилжүүлэг 37.3 хувь, хүүгийн зардал 10.5

хувь, татаас 3.6 хувийг тус тус эзэлж байна. Хөрөнгийн зардалд 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2.8 их наяд төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 75.3 хувиар буюу 1.2 их наяд төгрөгөөр өсжээ. Хөрөнгийн зардал өсөхөд барилга байгууламжийн зардал 2.1 дахин буюу 1.1 их наяд төгрөг, их засварын зардал 91.7 хувь буюу 77.9 тэрбум төгрөг, бусад хөрөнгийн зардал 7.3 хувь буюу 22.7 тэрбум төгрөг, стратегийн нөөц хөрөнгийн зардал 61.0 хувь буюу 7.4 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Хөрөнгийн зардал барилга байгууламжийн зардал 75.1 хувь, бусад хөрөнгийн зардал 11.8 хувь, тоног төхөөрөмжийн зардал 6.6 хувь, их засварын зардал 5.8 хувь, стратегийн нөөц хөрөнгийн зардал 0.7 хувийг тус тус эзэлж байгаа нь өмнөх оноос барилга байгууламжийн зардал 13.4 пункт, их засварын зардал 0.5 пунктээр өсөж, харин бусад хөрөнгийн зардал 7.5 хувь, тоног төхөөрөмжийн зардал 6.5 хувь, стратегийн нөөц хөрөнгийн зардал 0.1 пунктээр тус тус буурчээ.

Монгол Улс 2019 онд нийт 152 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 13.7 тэрбум американ доллар, үүнээс экспорт 7.6 тэрбум американ доллар, импорт 6.1 тэрбум американ доллар түрүүлж байна. Нийт бараа эргэлтийн

хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар буюу 860.6 сая америк доллар, үүнээс экспорт 8.7 хувиар буюу 608.0 сая америк доллароор, импорт 8.0 хувиар буюу 252.6 сая américик доллароор тус тус өсжээ.

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2014 оноос эхлэн ашигтай гарч эхэлсэн бөгөөд 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр ашгийн хэмжээ 1.5 тэрбум доллар түрүүлж өмнөх оноос 31.3 хувиар буюу 355.4 сая доллароор өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 12 сард улсын хэмжээнд өмнөх оны эцсээс 5.2 хувиар өссөн байна. Инфляцын түвшин 2016 оны 12 сард 1.3 хувь, 2017 оны 12 сард 6.4 хувь, 2018 оны 12 сард 8.1 хувь гарч байсан бол 2019 оны 12 сард 5.2 хувь болж өмнөх оноос 2.9 пунктээр буурсан байна. Инфляцийн жилийн дундаж түвшин 2018 онд 6.8 хувь байсан бол 2019 онд 7.3 хувьд хүрлээ.

Банк бус санхүүгийн байгууллагын зах зээл

2019 оны III улирлын байдлаар Монгол улсын санхүүгийн зах зээлд нийт 539 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс тайлант улиралд нийт байгууллагуудын дийлэнх нь болох 494 буюу 91.6 хувь нь зээлийн үйл ажиллагааг эрхэлж, 8.4 хувь нь зөвхөн гадаад валют арилжааны үйлчилгээг дагнан эрхэлж байна.

Нийт хөрөнгийн хэмжээ 2019 оны III улирлын байдлаар 1.6 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 35.5 хувь буюу 426.5 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна. Активын бүтцээс харвал салбарын хөрөнгийн өсөлтийн 83.9 хувийг зээлийн өсөлт, пассивын бүтцээс харвал 63.4 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт тус тус бүрдүүлж байна.

Мөн салбарын зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн үйлчилгээний хүртээмж сайжирсан бөгөөд салбарын зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.6 дахин нэмэгдэж 383.7 мянга хурсэн бол нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 1.5 дахин нэмэгдэж 2.3 саяд хурсэн дүнтэй байна.



Хараат бус аудитын
тайлан

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"Ард Кредит ББСБ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санал дүгнэлт

Бид 2019 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Ард Кредит ББСБ" ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр "Ард Кредит ББСБ" ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлантуугацааны санхүүгийн тайландахийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байдаг. Гэхдээ бид энэхүү асуудлын талаар ямар нэг баталгаа илэрхийлэхгүй. Харин 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар доорх асуудлыг аудитын гол асуудал болгон оруулсан.

Ард койны хөрөнгө оруулалтын талаар: Тайлангийн хугацаанд компани Ард Бит ХХК-ийн гаргасан Ард койноос (ARDX) 299,868,396.61 ширхгийг худалдан авч харилцагч нарт урамшуулал олгох, зарим холбоотой талуудад төлөх өр төлбөртөө шилжүүлэх замаар 209,541,689.9 ширхгийг буцаан зарцуулсан. Тайлангийн хугацааны эцэст компани 90,326,706.71 койн эзэмшиж байгаа ба койны үлдэгдлийг www.coinmarketcap.com крипто валютын бирж дээрх арилжааны ханшаар (нэг бүрийг нь 4.71 төгрөг) хөрвүүлэн тайлагнасан ба санхүүгийн байдлын тайлан дахь авлагын

дунд багтсан. Хагас жил болон жилийн эцсийн санхүүгийн тайланд бодит үнэ цэнийн хэмжилт хийж нийт 618,613.1 мянган төгрөгийн үнэлгээний цэвэр олз хулээн зөвшөөрсөн ба тайлангийн хугацаанд хулээн зөвшөөрсөн цэвэр ашгийн 28 хувийг эзэлж байна. Мөн крипто валютын үйл ажиллагаа хэрхэн явуулахыг хууль тогтоомжоор хулээн зөвшөөрсөн эсвэл хориглосон зохицуулалт байхгүй бөгөөд СТОУС, Монгол улсын нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулиар ч бүртгэл, тайлагналын талаар зохицуулалт байхгүй байна.

Аудитын горим: Аудитаар Койнтой холбоотой холбогдох дансны хуулга, бодит үнэ цэнийн мэдээлэл зэрэг нягтлан бodoх бүртгэл, санхүүгийн тайлагналд ашигласан мэдээллийг шалгасан ба цаашид крипто валюттай холбоотой ажил гүйлгээ нэмж гарах, цаашлаад санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлөхүйц ажил гүйлгээ болж цар хүрээ нь нэмэгдэх магадлалтай гэж үзэн аудитын гол асуудалд орууллаа.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хулээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бурддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байдаг. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид жийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хулээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хулээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хулээх ба тасралтгүй байдлын суурин талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хулээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан.

Мөн бид:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Гэхдээ алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гүйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох буртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв байгууллагын тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд байгууллагын тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамаарлтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат буд байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээллэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байdag асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайлан харуулсан.

Бусад

Энэхүү тайлан Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн ба бид тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



2020 ОНЫ 03 ДУГААР
САРЫН 09-НИЙ ӨДӨР

Санхүүгийн байдлын тайлан

		Тодруулга	2019.12.31 мянган төгрөг	2018.12.31 мянган төгрөг
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгөн хөрөнгө	6.1.	1,873,425.1	1,123,728.8	
Зээл, зээлийн хүүний авлага /цэвэр/	6.2.	18,058,608.1	7,545,803.0	
Богино хугацаат хөрөнгө оруулалт	6.3.-6.4.	668,073.5	671,276.9	
Бусад санхүүгийн хөрөнгө	6.5.	1,527,771.7	750,307.9	
Бусад хөрөнгө	6.10.-6.11.	279,594.3	164,391.7	
Эргэлтийн хөрөнгийн дүн		22,407,472.7	10,255,508.2	
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө (цэвэр)	6.12.	107,404.3	168,974.3	
Биет бус хөрөнгө (цэвэр)	6.13.	578,782.3	47,284.8	
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө				
Хойшлогдсон татварын хөрөнгө				
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		686,186.6	216,259.1	
НИЙТ ХӨРӨНГӨ		23,093,659.3	10,471,767.3	
ӨР ТӨЛБӨР				
Богино хугацаат хөрөнгө оруулалт				
Бусдаас авсан зээл	6.6.	2,540,635.5	554,605.8	
Бусад эх үүсвэр	6.7.	5,130,197.0	3,858,575.2	
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	6.8.	772,215.8	259,508.9	
Бусад санхүүгийн өр төлбөр	6.9.	646,694.0	198,366.1	
Татвар шимтгэлийн өглөг	6.14.	55,702.6	66,016.2	
Богино хугацаат өр төлбөрийн дүн		9,145,444.9	4,937,072.2	
Үрт хугацаат өр төлбөр				
Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл	6.6, 6.9.	923,216.2	661,292.8	
Бусад эх үүсвэр	6.7.	2,285,477.5	1,112,000.0	
Хойшлогдсон татварын өглөг	6.14.	47,091.7	4,018.8	
Үрт хугацаат өр төлбөрийн дүн		3,255,785.4	1,777,311.5	
Нийт өр төлбөр		12,401,230.4	6,714,383.8	
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ				
Энгийн хувьцаа	6.15.	2,800,000.0	2,100,000.0	
Нэмж төлөгдсөн капитал	6.15.	4,048,466.6		
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	6.15.	3,843,962.3	1,657,383.5	
Нийт өөрийн хөрөнгө		10,692,428.9	3,757,383.5	
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		23,093,659.3	10,471,767.3	

Орлого үр дүн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тодруулга	2019.12.31 мянган төгрөг	2018.12.31 мянган төгрөг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	6.16.	3,844,785.9	1,788,320.3
Хүү түүнтэй адилтгах зардал	6.17.	(1,288,812.5)	(914,631.4)
Цэвэр хүүний орлого		2,555,973.4	873,688.9
Гадаад валют арилжааны орлого	6.23.	1,631.1	1,542.0
Үнэт цаасны арилжааны орлого	6.23.		208,404.7
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн олз	6.23.	67,527.2	9,950.1
Үнэт цаасны үнэлгээний олз	6.23.	35,111.3	108,708.2
Койноорх хөрөнгө оруулалтын үнэлгээний олз	6.23.	618,613.1	
Үйлчилгээний орлого	6.18.	2,071,498.6	114,762.3
Гадаад валют арилжааны орлого	6.23.	1,631.1	1,542.0
Үнэт цаасны арилжааны орлого	6.23.		208,404.7
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн олз	6.23.	67,527.2	9,950.1
Үнэт цаасны үнэлгээний олз	6.23.	35,111.3	108,708.2
Койноорх хөрөнгө оруулалтын үнэлгээний олз	6.23.	618,613.1	
Үйлчилгээний орлого	6.18.	2,071,498.6	114,762.3
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн гарз	6.23.	(87,235.5)	(25,980.8)
Үнэт цаасны үнэлгээний гарз	6.23.	(9,209.6)	
Боловсон хүчинтэй холбоотой зардал	6.19.	(788,104.9)	(357,348.1)
Үйл ажиллагааны бусад зардал	6.20.	(1,235,794.7)	(548,799.3)
Үйл ажиллагааны ашиг		3,225,730.4	368,600.8
Эрсдэлийн сангийн зардал	6.21.	(797,955.3)	(131,274.1)
Үндсэн үйл ажиллагааны ашиг, алдагдал		2,427,775.1	237,326.8
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	6.22.	43,798.5	235,282.8
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	6.22.	(36,172.7)	(81,344.8)
Татварын өмнөх ашиг (алдагдал)		2,435,400.9	391,264.8
Орлогын албан татварын зардал	6.24.	(248,822.1)	(49,218.9)
Тайлант жилийн татварын дараах ашиг		2,186,578.8	342,045.9
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, (бууралт)			
Нийт дэлгэрэнгүй орлого		2,186,578.8	342,045.9
Нэгж хувьцаанд ногдох ашиг /төгрөгөөр/	6.25	8.24	1.63

Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,312,500.0	787,500.0	1,635,337.6	3,735,337.6
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа				
Залруулагдсан үлдэгдэл	1,312,500.0	787,500.0	1,635,337.6	3,735,337.6
Хувьцаат капиталын өсөлт (бууралт)	787,500.0			787,500.0
Зарласан ногдол ашиг			(320,000.0)	(320,000.0)
Нэмж төлөгдсөн капиталын өсөлт, (бууралт)		(787,500.0)		
Тайлант үеийн цэвэр ашиг			342,045.9	342,045.9
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,100,000.0	-	1,657,383.5	3,757,383.5
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа				
Залруулагдсан үлдэгдэл	2,100,000.0	-	1,657,383.5	3,757,383.5
Хувьцаат капиталын өсөлт (бууралт)	700,000.0			700,000.0
Зарласан ногдол ашиг				
Нэмж төлөгдсөн капиталын өсөлт, (бууралт)		4,048,466.6		4,048,466.6
Тайлант үеийн цэвэр ашиг			2,186,578.8	2,186,578.8
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,800,000.0	4,048,466.6	3,843,962.3	10,692,428.9

Мөнгөн гүйлгээний тайлан

	2019.12.31 мянган төгрөг	2018.12.31 мянган төгрөг
1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	51,592,851.3	17,179,661.4
Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл	4,689,500.3	2,490,500.0
Бонд гаргалтаас хүлээн авсан	1,205,706.8	-
Харилцагчдад олгосон зээлийн эргэн төлөлт	31,472,375.5	10,574,069.9
Зээлийн хүүгийн орлого	3,529,416.2	1,812,649.5
Үнэт цаасны хүүгийн орлого		3,618.6
Харилцах дансны хүүгийн орлого	13,495.1	6,767.3
Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	120,978.5	17.5
Гадаад валютын арилжааны орлого	1,631.1	1,542.0
Үнэт цаасны арилжааны орлого		208,404.7
Гадаад валютын ханшийн зэрүү		
Итгэлцлийн үйлчилгээний орлого	4,304,143.0	1,993,000.0
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	1,696,830.0	85,634.4
Бусад үйлчилгээний орлого	4,558,774.8	3,457.5
1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	50,865,717.9	17,136,999.4
Бусдаас авсан зээлийн эргэн төлөлт	1,995,818.1	2,851,759.8
Бонд эргэн дуудахад төлсөн мөнгө	834,000.0	9,000.0
Харилцагчдад олгосон зээл	41,696,780.0	10,124,496.1
Бусдаас авсан зээлийн хүүгийн зардал	75,959.1	42,784.2
Төслийн зээлийн санхүүжилтийн хүүгийн зардал		6,303.3
Өрийн бичгийн хүүд төлсөн мөнгө	252,605.9	331,264.1
Үндсэн ба нэмэгдэл цалин	690,378.1	316,564.4
Ажилтнуудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	9,661.2	2,010.0
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд төлсөн мөнгө	86,910.5	67,084.0
Албан томилолт, сургалтын зардал	27,290.6	13,590.8
Түрээс, мөнежментийн зардалд төлсөн мөнгө		
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	19,292.7	20,922.4
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	31,910.0.	5,323.0
Татвар, даатгалд төлсөн мөнгө	243,234.1	100,762.2
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	117,143.7	48,605.1
Үнэт цаас болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой гарсан мөнгө		310.7
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	2,214.1	30,405.5
Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө	3,191,656.1	1,260,632.0
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөх үйлчилгээний мөнгө	101,400.0	34,325.0
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	7,282.0	7,040.0
Ногдол ашгаар олгосон мөнгө		36,576.0
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	1,482,181.7	1,827,240.8
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	727,133.4	42,662.0

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

2019.12.31
мянган төгрөг

2018.12.31
мянган төгрөг

2.ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

2.1 Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	11,609.8	9,757.4
--	----------	---------

Үндсэн хөрөнгө ба өмчлөх бусад хөрөнгө борлуулсны орлого

Ногдол ашгийн орлого	1,208.2	6,299.9
----------------------	---------	---------

Хандив

Бусад	10,401.6	3,457.5
-------	----------	---------

2.2 Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	34,172.7	23,964.8
---	----------	----------

Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	28,007.7	21,636.1
---------------------------------------	----------	----------

Хандив	2,000.0	
--------	---------	--

Торгуулийн зардал	539.6	2,328.7
-------------------	-------	---------

Бусад	3,625.4	
-------	---------	--

Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(22,562.9)	(14,207.4)
---	------------	------------

Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	749,696.3	28,454.6
--------------------------	-----------	----------

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,123,728.8	1,095,274.2
---	-------------	-------------

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,873,425.1	1,123,728.8
--	-------------	-------------

Хамтран ажиллагч байгууллагууд





info@ardcredit.com



ardcredit.com



Ард Кредит
цэнэг.эрдэмтэй.өнгөлөх
2019



41
7731 0262, 32 1899